


ДОТООД ХУДАЛДАА


Монгол Улсын бөөний болон жижиглэн худалдааны нийт борлуулалт 2016 онд 16773.6 тэрбум төгрөг байсан ба үүнээс 13810.8 тэрбум төгрөг (82.3%) нь нийслэлд дангаараа хийгдсэн байна. Худалдааны нийт борлуулалтын 51.6 хувийг бөөний, 48.4 хувийг жижиглэн худалдаа эзэлж байна.

Зураг 1. Худалдааны нийт борлуулалт, тэрбум төгрөг



2016 онд нийслэлд 4383 хүнсний дэлгүүр, 44 бөөний худалдааны төв, 29 зах, 757 түргэн үйлчилгээний цэгүүд жилийн турш үйл ажиллагаа явуулсан байна. Эдгээр худалдааны цэгт бөөний болон жижиглэнгийн нийт 13810.8 тэрбум төгрөгийн худалдаа хийгдсэн нь 2012 оныхоос 1852.2 тэрбум төгрөгөөр (15.5%), 2013 оныхоос 1636.0 тэрбум төгрөгөөр (13.4%) нэмэгдэж, харин 2014 оныхоос 775.0 тэрбум төгрөгөөр (5.3%), 2015 оныхоос 804.0 тэрбум төгрөгөөр (5.5%) тус тус буурсан байна.


Зураг 2. Худалдааны нэг цэгт ногдох хүний тоо, 2016 он



Хүснэгт 1. Бөөний болон жижиглэн худалдаа, тэрбум төгрөг

Үзүүлэлт		Нийт дүн	Үүнээс:	
			Бөөний худалдаа	Жижиглэн худалдаа
2012	Улсын дүн	13 350.0	7 668.5	5 681.5
	Нийслэлийн дүн	11 958.6	7 037.4	4 921.2
	Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	89.6	91.8	86.6
2013	Улсын дүн	14 456.4	7 078.6	7 377.8
	Нийслэлийн дүн	12 174.8	6 895.4	5 279.4
	Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	84.2	97.4	71.6
2014	Улсын дүн	16 980.5	7 809.7	9 170.8
	Нийслэлийн дүн	14 585.8	7 529.4	7 056.4
	Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	85.9	96.4	76.9
2015	Улсын дүн	17 698.7	7 683.2	10 015.5
	Нийслэлийн дүн	14 614.8	7 246.4	7 368.4
	Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	82.6	94.3	73.6
2016	Улсын дүн	16 773.6	7 820.9	8 952.7
	Нийслэлийн дүн	13 810.8	7 120.5	6 690.3
	Улсын дүнд нийслэлийн эзлэх хувь	82.3	91.0	74.7


Зураг 3. Худалдааны нийт борлуулалт, тэрбум төг



2016 онд Монгол Улсын хэмжээнд худалдааны нийт борлуулалт 16773.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт борлуулалтын 82.3 хувь нь нийслэлд, үлдсэн 17.7 хувь нь бусад аймгуудад хийгджээ.

Худалдааны салбарын нийт аж ахуйн нэгжийн 10.0 гаруй хувийнх нь жилийн борлуулалтын орлого 50 сая төгрөгөөс дээш байгаа бөгөөд эдгээр аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлого худалдааны нийт борлуулалтын орлогын 90.0 гаруй хувийг эзэлж байна.

Зураг 4. Худалдааны цэг, төрлөөр, 2016 он



Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа худалдааны нийт цэгийн 84.1 хувь нь хүнсний дэлгүүр, 14.5 хувь нь түргэн үйлчилгээний цэг, 0.8 хувь нь бөөний худалдааны төв байхад үлдсэн 0.6 хувийг хүнсний болон барааны зах эзэлж байна.